

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2019 ОНЫ  
12 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

**НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД**

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа зохион байгуулагдаж, 5 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Хурлаар 2 иргэнд гэр олгож, 16 иргэнийг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнаж, 1 иргэнд 300000 төгрөгийн тусламж өгөхөөр шийдвэрлэсэн. Мөн оны онцлох хүн болон, оны онцлох байгууллагыг шалгаруулсан байна.

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 34 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Аймгийн Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг 12 дугаар сарын 18, 19, 20-ны өдрүүдэд Сүмбэр, Шивээговь, Баянтал суманд зохион байгуулж, 2019 онд аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын мэдээлэл болон 2020 онд хийж хэрэгжүүлэх ажлын тухай мэдээллийг танилцуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлтэй хамтран 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдөр “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд ойтруулж, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн шинэ санал, санаачилгыг дэмжиж түгээн дэлгэрүүлэх зорилгоор илтгэлийн уралдаан зохион байгуулсан бөгөөд нийт 12 төрийн албан хаагч оролцсон.

**ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

2019 оны 12 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 5124,2 сая төгрөг төвлөрүүлэхээс, 6783.6 сая төгрөг төвлөрүүлж 132.3 хувьтай байна.

2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар бүртгэлтэй ХК-1, ХХК-296, ББН-5, ЗБН-10, Хоршоо-27, ОНӨҮГ-6, Салбар-70, Хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт байгууллага-57, Төрийн бус байгууллага-89, Шашны байгууллага-5, Сан-10 нийт хуулийн этгээд 593 байна.

Татварын хяналт шалгалтаар нийт 1210345,9 мянган төгрөгийн зөрчилд 89797,0 мянган төгрөгийн нөхөн татвар, 30436,5 мянган төгрөгийн торгууль, 45672,0 мянган төгрөгийн алданги, нийт 165905,5 мянган төгрөгийн шийтгэл оногдуулсан.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 7602,9 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 7602,9 сая.төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийн 915,3 сая төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

**Статистикийн чиглэлээр:** 2019 оны 11 дүгээр сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгыг бэлтгэж аймгийн болон хэлтсийн цахим хуудсанд байршуулж, хэвлэмэл хуудсаар 45, цахимаар 150 хэрэглэгчид хүргүүлсэн.

**Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр:**Төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 11 дүгээр сарын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа хэрэгжилт 93,9 хувьтай, тайлан шивэлт 100 хувьтай байна.

**Нийгмийн даатгалын сангаас олгосон:Тэтгэвэр**

№	Төрөл	2018.12.24		2019.12.24		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	
1	Өндөр настан	1644	6471835,6	1750	7274481,2	106
2	Тахир дутуу	335	884750,2	467	1044531,9	132
3	Тэжээгчээ алдсан	129	381623,2	131	388967,4	2

4	Үйлдвэрийн осол	46	264917,3	27	292582,8	-19
<b>Нийт дүн</b>		<b>2154</b>	<b>8003126,3</b>	<b>2375</b>	<b>9000563,3</b>	<b>221</b>

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж**

№	Төрөл	2018.12.24		2019.12.24	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/
1	ХЧТА тэтгэмж	1605	164483,6	1575	202736,2
2	ЖБА тэтгэмж	381	497898,0	388	607874,3
3	Оршуулга	76	76000,0	69	69000,0
4	ҮОМШӨ-ХЧТА	41	45270,0	11	4777,9
5	Ажилгүйдэл	197	279479,4	213	333719,2
<b>Нийт дүн</b>		<b>2300</b>	<b>1063131,0</b>	<b>2257</b>	<b>1218107,6</b>

**Сайн дурын даатгал:**

Сайн дурын даатгалын хамрагдалт	2018.12.24	2019.12.24
Шинээр	242	280
Мөнгө тушаасан	683	684
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	187708,8	248146,2

**ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр:** 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Шүүхийн тамгын газар, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтран гэмт хэрэгт насанд хүрээгүй холбогдогч, хохирогч тэдгээрт хийсэн дүн шинжилгээ, авах арга хэмжээ сэдэвт онол, практикийн бага хурал зохион байгуулсан бөгөөд 40 албан хаагч оролцсон.

**Архивын ажлын чиглэлээр:**

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 66 хөмрөгийн 4022 хадгаламжийн нэгжийн 903758 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, 4483 хадгаламжийн нэгжийн 968859 хуудас баримтыг скайнердаж 3296 хадгаламжийн нэгжийн 823696 хуудас баримтыг фотошопдон засварлаж, 5177 хадгаламжийн нэгжийн 276733 хуудас баримтыг цахимд холбосон. 15 иргэнд лавлагаа мэдээллээр үйлчилсэн байна.

**Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр гадаад паспорт захиалсан -27
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -52
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 26
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 4
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -2
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо -1
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 3
- Нас барсныг бүртгүүлсэн тоо -4
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -31
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо -30

**Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 12
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 35
- Гэрээний бүртгэл -15
- Барьцааны гэрээний бүртгэл - 218
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -6

**Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 4

- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -7

#### **Архивын чиглэлээр:**

- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар-143

Нийт 622 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн байна.

**Цагдаагийн хэлтэс нь:** 2019 оны эхний 11 сард 138 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 16-аар буюу 10.4 хувиар буурсан байна.

87 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19-өөр буюу 17.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Улсын хэмжээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх ажилд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хамтын ажиллагааг сайжруулах зорилго бүхий "ОЙЛГОЁ-ХҮНДЭЛЬЕ" аян зохион байгуулагдаж байгаа ба аяны талаар иргэд, төрийн алба хаагч нарт мэдээлэл өгч, нийт 16 төрийн байгууллагууд аяныг дэмжин, нэгдлээ.

"Ойлгоё-хүндэлье" аяны хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран лектор Г.Бандицэрэнг урьж, "Хувь хүний хөгжил амьдралын үнэ цэнэ" сэдвээр 4 удаагийн лекц зохион байгуулж 800 иргэнийг хамруулсан.

"Ойлгоё-Хүндэлье" аяны хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хорих 425 дугаар нээлттэй хорих ангийн алба хаагчид, Ус-Ду ОНӨААТҮГ-ын ажилчид, Баянтал сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 1-8 дугаар ангийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагч, Цагдаагийн хэлтсийн алба хаагчид тэдний гэр бүлийнхэн, Онцгой байдлын газрын алба хаагчид, Мэргэжлийн ахлагч бэлтгэх төвийн байнгын бүрэлдэхүүн, сонсогч нарт "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль", "Зөрчлийн тухай хууль", "Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрэм"-ээр сургалт зохион байгуулсан.

Шинэ жилийн баярыг гэмт хэрэг, зөрчилгүй, иргэдийн амар тайван байдлыг хангах зорилгоор "**Шинэ жил**" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж байна. Арга хэмжээний хүрээнд нийт 60 аж ахуйн нэгж байгууллагад шинэ жилийн баярыг зүй зохистой тэмдэглэн өнгөрүүлэх талаар мэдэгдэл хүргүүлээ. Мөн аж ахуйн нэгж байгууллагад сонор сэрэмжээ дээшлүүлж, архи согтууруулах ундааг зүй зохистой хэрэглэх талаар сэрэмжлүүлэг хүргэлээ.

Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, хүүхдийг замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох дадлыг эзэмшүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль дүрмийн мэдлэг олгох, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 5 сургуулийн сурагчдын дунд "Ногоон гэрэл-цагаан шугам 2019" тэмцээнийг зохион байгууллаа.

"ХИЧЭЭХ ӨДӨР" арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн 56 сурагч, 4 багшид зөвлөмж, бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, хурд үхэл, ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх зэрэг мэдээллийг иргэдэд орон нутгийн телевизээр хүргэсэн.

**Шүүхийн шинжилгээний алба нь:** Шүүхийн шинжилгээний албанаас хэргийн газрын үзлэгт 12 удаа оролцоноос зам тээврийн ослын 5, хулгайлах гэмт хэрэг 1, бусад хэргийн газрын үзлэгт 6 удаа оролцож, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 199 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги нь:**

Хоригдлуудыг нийгэмшүүлэх тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хугацаанаас өмнө суллагдах хүсэлт гаргасан 30 хоригдолд “Хөдөлмөрийн хууль”, “Халамжийн тухай хууль”-иар сургалт зохион байгуулсан.

2019 оны 1 дүгээр сараас 2019 оны 12 дугаар сарын 12-ныг хүртлэх хугацаанд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран хоригдлыг бичиг баримтжуулах буюу иргэний үнэмлэх шинээр болон дахин олгох, иргэний үнэмлэхний хугацаа /25-45 насны/ сунгах зэрэг зөрчлүүдтэй холбоотой нэр бүхий 58 хоригдлыг бичиг баримтжуулсан.

Хорих ангийн үйлдвэрлэлд түшиглэн хөдөлмөрийн дадлага олгох зорилгоор нийт 237 хоригдлыг гар урлал, даалин оёх, мужаан, сийлбэр, нэхий элдэх, сур элдэх, гөлөм оёх, блок хийх, эсгий хийх, ноос угаах зэрэг сургалтуудад хамруулсан.

Аймгийн Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежтэй хамтран ажиллах гэрээний дагуу 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сар хүртлэх хугацаанд “Уулын ажлын техникч” мэргэжлээр 13 хоригдол, “Уул уурхайн хүнд машин механизмын операторчин” мэргэжлээр 20 хоригдол, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Амгалан” мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд “Барилгын засал чимэглэлчин” мэргэжилээр 15 хоригдол, “Барилгын сантехникч” мэргэжлээр 14 хоригдол, нийт 62 хоригдлыг суралцуулж мэргэжил эзэмшүүлсэн байна.

Одоогийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн бетон арматурчин мэргэжлээр 12, гагнуурчин мэргэжилээр 15 хоригдол, аймгийн Политехникийн коллежид Хүнд машин механизмын операторчин мэргэжлээр 12, Хүнд машин механизмын засварчин мэргэжилээр 14 хоригдол нийт 65 хоригдлыг хамруулан сургаж байна.

Бичиг үсгийн чадваргүй 11 хоригдлыг аймгийн Насан туршийн боловсрол олгох төвтэй хамтран бичиг үсгийн чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулсан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бусаар ашигласан 7-15 хоригдлыг бүлгийн сургалтанд 7 хоногт 2-3 удаа жилийн хугацаанд 45 долоо хоногт нийт 90 удаа буюу давхардсан тоогоор 720 хоригдолд сургалт зохион байгуулсан. мөн согтууруулах ундаа хэрэглэн гэмт хэрэг үйлдсэн архины хамааралтай гэх 65 хоригдолд батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулсан.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** Урьдчилан сэргийлэх шалгалт 1, төлөвлөгөөт шалгалт 1, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 1 удаа хийж, улсын байцаагчийн 7 заалт бүхий 1 албан шаардлага, 5 дүгнэлт гарган хүргүүлсэн.

Шинэ жилийн баяртай холбогдуулан хүнсний аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, стандартын шаардлагыг хангуулах, үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдэд сэрэмжлүүлэг, зөвлөмж, зөвлөгөө өгөх зорилгоор 26 объектыг хамруулан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. Шалгалтаар нийт 42 зөрчил илрүүлж, хяналтын явцад 81 хувийг арилгуулж, 18 заалт бүхий 3 албан шаардлага гаргаж, 3 газарт хүргүүлсэн.

Шалгалтын явцад хадгалалтын хугацаа хэтэрсэн, хадгалалтын горим баримтлаагүйгээс чанар, аюулгүй байдал нь алдагдсан, хаяг шошго зөрчилтэй 8 нэрийн 74 ширхэг 183400 төгрөгийн бүтээгдэхүүнийг хураан авч, устгалын комисст шилжүүлсэн. Мөн чанар аюулгүй байдлын баталгаажилтгүй 4 төрлийн 6 дээжийг хими, нян судлалын лабораторийн шинжилгээнд хамруулсан.

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 11, гурилан бүтээгдэхүүний 8, хоолны 25, арчдас 20, нийт 64 дээжинд 2-9 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг хийж гүйцэтгэснээс эерэг сорьц 3 илэрсэн.

Иргэн төвтэй, үр дүнд чиглэсэн төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилгоор “Мэргэжлийн хяналтыг–Өрх бүрт” арга хэмжээг зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаар дамжуулан өрх бүрт хүнсний аюулгүй байдал, эрүүл орчинд өсөж хүмүүжих талаарх мэдээлэл өгөх, зөвлөх үйл ажиллагаа үзүүлж, сургалт зохион байгууллаа.

**Онцгой байдлын газар нь:** Газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг, борлуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас хамгаалах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээх станц,

шатахууны агуулах зэрэгт хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтаар 5 шатахууны агуулах, 14 шатахуун түгээх станцад гамшиг осол болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, давхардсан тоогоор гал түймэр гарч болзошгүй 43 зөрчил илрүүлж шалгалт хийх явцад болон газар дээр нь 5 зөрчлийг арилгуулж, 38 зөрчил дутагдлыг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 6, мэдэгдэл тавыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн, эрх бүхий албан тушаалтнуудад байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж ажиллаж байх талаар мэргэжил, арга зүйн заавар, зөвлөмжийг өгсөн.

12 дугаар сарын 06-ны өдөр ОУ-ын сайн дурын өдрийг тохиолдуулан Онцгой байдлын газар, Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран хүмүүнлэгийн үйлсийг дэмжигчдийн эгнээг өргөжүүлж, алдаршуулах зорилготой “Хүмүүнлэгийн өдөр”-ийг зохион байгуулсан. Өдөрлөгт 50 гаруй сайн дурын онцгой гишүүд оролцсон. Дээрхи иргэдэд сайн дурын иргэдийн эрх, үүрэг оролцоо сэдвээр мэдээлэл хийж, Улаанзагалмайн гишүүнчлэлийг нэмэгдүүлэн, тангараг өргүүлэн, олон жил хүмүүнлэгийн үйлсэд зүтгэсэн сайн дурын иргэдийг шагнаж урамшуулан ажилласан.

Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээнд гал түймрийн 2 дуудлагаар үндсэн болон туслах албаны авто машинтай 7 алба хаагч, 141 литр шатахуун, 17 тн ус зарцуулан үүрэг гүйцэтгэж, иргэний 50 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан.

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ,СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** Боловсролын мэргэжил дээшлүүлэх институттай хамтран “ЕБС-ийн сайжруулсан хөтөлбөрийн зөвлөн туслах үйл ажиллагаа” сэдэвт сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус сургалтанд 25 багш хамрагдсан. Сургалтаар сургуулийн өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ хийх санал асуулга нэгтгэх Google form ашиглах дадлага, сурлагын амжилтын хөндлөнгийн үнэлгээний даалгаврын тохироц, даалгавар сонголтын дадлага ажил хийсэн.

Боловсролын үнэлгээний төвтэй хамтран орон нутгийн үнэлгээний шинжээч бэлтгэх “Хөтөлбөрт суурилсан үнэлгээний арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын нэрэмжит математикийн массын олимпиадыг зохион байгуулсан. тус олимпиадад 5-12 дугаар ангийн 1600 сурагч оролцсон.

**Биеийн тамир, спортын чиглэлээр:** Спортын салбар холбоодын шинэ жилийг 2019 оны 12 дугаар сарын 20- зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний үеэр “Биеийн тамир спортыг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд дэлхий, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн 15 тамирчин, 5 дасгалжуулагчид Засаг даргын нэрэмжит мөнгөн урамшуулал болох 12500,0 мян төгрөгийн дэмжлэг урамшуулалыг олгосон.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Бага олимп" спортын наадмын чөлөөт бөхийн аварга шалгаруулах тэмцээнийг 12 дугаар сарын 08-нд зохион байгуулсан. Тэмцээнд нийт 4 сургуулийн 90 гаруй тамирчин оролцсон.

Олон Улсын хэмжээний мастер Д.Ариунжаргал нь 2019 оны 12 дугаар сарын 02-07-ны өдрүүдэд Малайз улсын Саравак хотод Мастеруудын ази тивийн аварга шалгаруулах тэмцээний 40-44 насны ангилалд 5000м зайд мөнгөн медаль, 10км-т мөнгөн медаль, 1500м-т 8 дугаар байр, саадтай 3000м-т шагналт 5 дугаар байрт шалгарсан амжилт үзүүлсэн.

**Соёл, урлагийн чиглэлээр:** Сүмбэр сумын 4,5,6 дугаар багийн малчдад угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 3 багийн 195 малчид оролцсон.

**Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, оролцоо, эрх хамгааллын чиглэлээр:** Мэргэжил сонголтын бүлгийн гишүүдийг чадавхижуулан ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн мэргэжил сонголтонд тулгарч буй асуудлууд, тэдгээрийг даван туулах, холбогдох мэдээ мэдээллийг олж авч бусадтайгаа хуваалцах, зөв сонголт хийхэд нь туслах,

зөвлөгөө өгөхөд бэлтгэх зорилгоор Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх “Мэргэжил сонголтын бүлгэм”-ийн гишүүдийг чадавхижуулах ээлжит сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг МУИС-ын Мэргэжлийн зөвлөгч бэлтгэх магистрантур Ч.Анхтуяа чиглүүлэн явуулсан. Сургалтанд мэргэжил сонголтын бүлгэмийн 9 гишүүн хамрагдсан.

Аймгийн Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: Орон нутгийн ажилгүй залуучуудын аж ахуй эрхлэлтийн болон бизнес санаа олох хайх идэвхи, санаачлагыг нэмэгдүүлэх, санхүүгийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэхээс гадна төслийн тухай ойлгол төгөх, төсөл бичиж боловсруулах арга зүйд сургах, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Дэлхийн Зөн Олон улсын байгууллагын Бор-Өндөр1 ОНХ-ийн “Хөгжих 100 өрх”-ийн 30 иргэнд “Санхүүгийн боловсрол олгох, төсөл бичих арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөл болон сумдын залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн туршлагаа хуваалцах, шилдэг ажилласан зөвлөлийг шалгаруулж, урамшуулах арга хэмжээг 2019 оны 12 сарын 04-ний өдөр зохион байгуулсан. 2019 оны шилдэг зөвлөлөөр Баянтал сумын залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөл шалгарсан

**Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр:** Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 17 дахь удаагаа зохион байгуулж буй “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээг 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. “Иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагаанд 16 настнуудын төлөөлөл болох 17 хүүхэд Монгол Улсын Иргэний андгайг уншин тангараг өргөж, Монгол улсын иргэний үнэмлэх, батламжаа гардан авсан.Тус үйл ажиллагаанд Ерөнхий боловсролын сургуулийн нийт 80 сурагч хамрагдсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Дэлхийн Зөн Бор-Өндөр 1 ОНХ, Дуу бүжгийн боржигин чуулгатай хамтран 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр “Оны онцлох хүүхэд” хүүхдийн нэгдсэн шинэ жилийн арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд нийт 150 хүүхдийн урлагийн тоглолт болж аймгийн оны онцлох хүүхдүүд, онцлох багш нарыг шалгаруулан шагнаж урамшууллаа.

#### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

Үзүүлэлт	2018 оны 12 сар	2019 оны 12 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	471	419
Гэрийн төрөлт	0	1
Амьд төрсөн хүүхэд	470	421
Амьгүй төрөлт	1	3
Нас баралт	64	58
Эмнэлгийн нас баралт	9	10
Хоног болоогүй нас баралт	3	3
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	5
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	5143	4429
Амбулаторийн үзлэг	109970	86883
Халдварт өвчин	262	159

Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Солонгосын Олон улсын эрүүл мэндийн сан “КОФИН” -ын санхүүгийн болон техникийн туслалцаатайгаар хэрэгжиж буй “Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь”

төсөлд Шивээговь сум хамрагдаж, алслагдсан малчин, иргэдийг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, эрт илрүүлэг шинжилгээнд хамруулсан. Төслийн үр дүнд:

- Сумын эрүүл мэндийн төв тоног төхөөрөмж, оношлуураар хангагдаж, Шивээговь сумын нийт хүн амын 40 хувь болох 1552 иргэнийг эрүүл мэндийн анхан шатны урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 100 хувь хамруулсан. Мөн онош тодруулах шаардлагатай 468 иргэнийг 2 дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлсэн.

- Хүн амын нэгдсэн мэдээллийн сантай болж, 746 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгийн ач холбогдол эрүүл мэндээ хамгаалах талаар сургалт сурталчилгааг зохион байгуулан иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, хандлага 67,6 хувьтай байсан бол төслийн дараа 94,9 хувь болж 27,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

- Эрүүл мэндийн анхан шатны үзлэг шинжилгээнд хамрагдвал зохих хүн амын 32.8 хувийг Эрүүл мэндийн төвийн амбулаторид суурилсан тусламж үйлчилгээгээр, 67.2 хувийг явуулын тусламж үйлчилгээгээр үзлэгт хамруулсан. Уг төсөл хэрэгжсэнээр тус сумын эрүүл мэндийн төвийн эмч нарын мэдлэг чадвар дээшилж оношлогоо эмчилгээ сайжирсан.**Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:** 25 буюу түүнээс дээш ажилтантай 36 аж ахуйн нэгж байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Зөрчлийн тухай хуулиар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Аймгийн хэмжээнд 36 аж ахуйн нэгж, байгууллагад 94 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 2018 онд 54 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байсан бол 2019 оны 12 дугаар сарын байдлаар 38 байгууллагад 76 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангаж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 27 хувиар нэмэгдсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй аж ахуй нэгж байгууллагуудаас хуулийн дагуу ний 1296,0 мян төг төвлөрүүлэхээс 9 байгууллагын 25413,1 мян.төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.

2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Дэлхийн зөн Бор-өндөр-1” ОУБ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдэд хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнгийн сэтгэл зүйч Н.Тайванжаргал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцаж ажиллах арга барил” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулан нийт 14 эцэг, эх хамрагдлаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг 12 дугаар сарын 3-ны өдөр зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 70 хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцсон.

### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Мал, аж ахуйн чиглэлээр:** Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газартай хамтран Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилт, өнөөгийн байдал, цаашдын зорилт, хөдөө аж ахуйн салбарын төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчидтэй хамтран ажиллах зорилт, чиглэл тодорхойлох зорилгоор “**Хамтын хүч хөгжлийн тулгуур**” хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, 65 иргэн хамрагдсан. Хэлэлцүүлгйн үр дүнд иргэд хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэр, түүний хэрэгжилтийн талаар мэдээлэлтэй болсон. Мөн хөдөө аж ахуйн салбарт баримталж буй бодлого шийдвэр, төлөвлөлтийг сурталчилж, 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд оруулах санал авсан.

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд өнгөрсөн жилийн өвс 80 тн, тэжээл 26 тн, Сүмбэр сум 73 тн өвс, Баянтал сум 20 тн өвс, 3.5 тн тэжээл, Шивээговь сум 14 тн өвс, сумдын аюулгүй нөөцөд нийт 107 тн өвс, 3.5 тн тэжээл нөөцөлсөн.

Малх отрын бүсэд 5 аймгийн 90 өрхийн хонин толгойд шилжүүлснээр 111.0 мян.толгой мал оторлож байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас санаачлан Монгол Улсын Ерөнхий Сайдын ивээл дор “Мал зүйчдийн улсын зөвлөгөөн”-нд 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Зөвлөгөөний өмнө Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг,

нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын төлөөлөлтэй уулзаж, орон нутгийн өвөлжилтийн байдал, цаг үеийн ажлын явцыг сонсож, үүрэг чиглэл өгсөн. Уулзалтын үеэр ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан Мал үржүүлэг, технологийн ажлын гол хэрэгсэл болох зоо /палкметр, лентметр, циркуль, бод, бог малын зохиомол хээлтүүлгийн иж бүрдэл, бог малын пүү/ багажийг аймгийн Мал үржлийн албанд гардуулж өгсөн.

Улсын төсвийн 75.0 сая төгрөгийн хөрөнгөөр бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар тэмцэх ажил 81.3 хувьтай хийгдэж дууссан.

Монгол улсад атар газар эзэмшиж, газар тариаланг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ахмад тариаланчдын судалгааг гаргаж, төрийн болон салбар, орон нутгийн шагналд 36 хүнийг тодорхойлж “Атарчны алдар медаль”-иар 3, “Говьсүмбэрийн төлөө медаль”-иар 3, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 1, “Атрын 60 жилийн ойн медаль”-иар 25, ХХААХҮСалбарын “Тэргүүнийн ажилтан” цол тэмдгээр 4 хүн шагнагдсан.

Аймгийн брэнд бүтээгдэхүүний онцлох тэмдэг, хаяг шошгын загварыг бий болгож баталгаажуулах, хэрэглэж хэвшүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд хэрэглээний соёлыг бий болгож, аймгийн брэнд бүтээгдэхүүнийг танилцуулах, Засгийн газрын 287 дугаар тогтоолоор батлагдсан “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор уламжлалт модон торх, ган хувин, ширэн хөхүүр, даавуун тор, гоёл чимэглэлийн уут, савны урлалыг дэмжиж, брэнд болгох ажлыг зохион байгуулж, даавуун болон цаасан тор, уутны хэрэглээг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зорилгоор 3 сумын хөнгөн үйлдвэрлэл, гар урлалын бүтээгдэхүүний үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгж, иргэд, чөлөөт уран бүтээлчид, дизайнеруудын дунд зохион байгууллаа. Уралдаанд нийт 12 иргэний 54 бүтээл ирүүлснээс удирдамжийн дагуу шалгуур үзүүлэлтээр дүгнэн, шагналт 7 байранд өргөмжлөл, мөнгөн шагналыг олгосон.

**Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2019 оны 12-р сарын үнийн мэдээ**

Есдүгээр сарын сүүлч 12 дугаар сарын эхээр малчдаас зах зээлд нийлүүлэгдэж буй махны нийлүүлэлт ихсэж байгаа тул зах зээлд худалдаалагдаж буй үхрийн /ястай, цул/ махны үнэ 500 төгрөгөөр, ямааны мах /ястай/ 500 төгрөгөөр, төмс болон зарим хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-200 төгрөгөөр буурсан бол ургамлын тос 50 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан
1	Үхрийн мах	Ястай	8500	6000	-500
		Цул	10000	10000	-500
2	Хонины мах	Ястай	6500	4500	-
		Цул	9000	8500	-
3	Адууны мах	Ястай	6500	5000	-
		Цул	9500	9000	-
4	Ямааны мах	Ястай	5000	4000	-500
		цул	9000	8500	-
5	Тахианы мах	Гуя	8500	8500	
		мөч	9200	8500	
6	Лууван	монгол	2000	1500	-
		хятад			
7	төмс	монгол	1000	500	-50
		хятад			
8	Байцаа	монгол	1500	1200	-300
		хятад			-
		монгол			-



9	чинжүү	хятад	7000	6800	
10	Манжин	монгол	1200	1200	-50
		хятад			-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	2000	1600	-
		Хятад	1600	1200	-
12	Улаан лооль	монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	монгол	3500	3000	-
14	Элсэн чихэр	монгол	2100	1800	-
15	Будаа	Цагаан задгай кг	2500	2000	-100
		Шар слава кг	3100	2900	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	2000	1500	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3000	2950	-
17	Тараг	Задгай	2500	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	800	-
19	Өндөг	ОХУ	450	300	-5
		Монгол	400	250	-15
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1480	1400	-
		Задгай 1-р зэрэг	1100	1080	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	1650	1600	-
		Савласан дээд	1650	1600	-
		Савласан 1-р зэрэг	1300	1200	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
21	Ургамлын тос	Олейна	5500	4800	+50
		Алтан	3800	3600	-
22	Гоймон	Алейка	1600	1500	-
		А/тариа савхан	1000	900	-

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нөхөрлөлийн үндэсний холбоотой хамтран 2 жилд 1 удаа зохион байгуулагддаг салбарын нөхөрлөлүүдийн чуулга уулзалт Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа. Уг чуулган, үзэсгэлэнгийн арга хэмжээнд аймаг орон нутгаа төлөөлөн Хээнций уулын нөхөрлөл ажилттай оролцож үйл ажиллагаагаа танилцууллаа.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор жил бүр Улсын тусгай хамгаалалтай газар нутагт амьдардаг аргаль хонины идэш тэжээлд зориулсан биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн 50 боодол өвс, 1 тн хужрыг тавилаа. Цаашид авах арга хэмжээнд зориулан 330 тн өвс, 4 тн хужирыг нөөцлөөд байна.


“Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгжид урамшуулал олгох” тухай 2015 оны аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан журмын дагуу 2019 онд 1 ААН байгууллага, 16 иргэний 1937 ширхэг мод, бутыг тоолж иргэдэд нийт 19.670.030 төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас урамшуулал хэлбэрээр олголоо.

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 12 дугаар сард 8 хугацааны мэдээг 248 удаа, климат агро дундаж хөдөө аж ахуйн тойм болон 10 хоногийн тойм мэдээг 3 удаа, сарын тойм мэдээг 1 удаа тус тус төв станцад дамжуулсан.

12 дугаар сарын цаг уурын тойм мэдээгээр: 22, 24-ний өдрүүдэд цас орсон. Нийт 3.6 мм тунадастай. Салхи ихэнхи хугацаанд 3-8 м/сек, зарим үед 9-11 м/сек хүрч салхилав. Агаарын дундаж температур 13.5 градус хүйтэн, хамгийн хүйтэн нь 18-ны шөнө 27,5 градус хүйтэн, хамгийн дулаан нь 08-ны өдөр 3.5 градус хүйтэн байсан.

12 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар мал аж ахуйд зохиогдож байгаа ажил, малын бэлчээрлэлтэнд цаг агаарын байдал хэвийн ажил саатаагүй. Бог, бод малын тарга хүч сайн, худгийн болон цасны усаар ундаалж байна. Нийт нутгийн 90 орчим хувь нь цасан бүрхүүлээр хучигдсан бөгөөд цасны дундаж зузаан 4 см байна.

Энэ сард агаар бохирдуулагч элементүүд болох азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ), хүхэрлэг хийн давхар ислийг ( $\text{SO}_2$ ) хоногт 3 удаа, нийт 15 сорьцыг авч 45 удаа шинжилгээ хийсэн. 12 дугаар сарын 1-20-ны өдрүүдийн дээжинд шинжилгээ хийсэн ба шинжилгээний дүнгээр дундажлахад азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ) 0.015, сарын хүлцэх агууламж нь 0.050, хүхэрлэг хийн давхар исэл ( $\text{SO}_2$ ) 0.017, сарын хүлцэх агууламж 0.050 байгааг харахад хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна.



**Тээвэр, авто замын талаар:** Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 2019 оны жилийн эцсийн байдлаар 4139 тээврийн хэрэгсэл хамрагдахаас 5357 тээврийн хэрэгсэл хамрагдаж, 129.4 хувьтай байна.

Хот хооронд 631 иргэн, сум хооронд 36 иргэн зорчиж, 36 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдэн, ачааны 1500 дагалдах хуудас, 1600 замын хуудас олгосон байна.

## Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:

Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулсан.

Мөн Баянтал, Сүмбэр сумын 6 байршил бүхий 122507 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан.

Аймаг, сумдын Засаг даргын захирамжийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Сүмбэр суманд 2 байршилд, Баянтал суманд 1 байршилд тус тус газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг газрын цахим биржээр зохион байгуулсан.


Аймгийн ИТХ-ын 2018 оны 10 дугаар тогтоолын дагуу 2019 онд газрын төлбөрийн орлого 163 811.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 208 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 128 хувьтай байна. Үүнд:

- 48 аж, ахуйн нэгжээс – 182565632.84 төгрөг
- 219 иргэдээс – 16962660 төгрөг
- 31 төрийн байгууллагаас – 10262035.5 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

Улсын төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгөөр барилга, байгууламж паспортжуулах ажлын тендер шалгаруулалтаар ШУТИС-н дэргэдэх “Реконстракшн төв” шалгарч, гэрээ байгуулан 2019 оны 12 дугаар сарын 14-ний өдөр эхлээд байна.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Энэ сард нийт давхардсан тоогоор 83 тендерийн урилгыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.govisumber.gov.mn](http://www.govisumber.gov.mn) сайтад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд оруулсан. Зарласан тендерүүдийг хөрөнгө оруулалтаар дараахь байдлаар зарласан байна.

Үүнд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 23, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 16, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 5, автозамын сангийн хөрөнгөөр 1, нийт 48 ажлыг цахим системээр зарлаж ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.



## ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

### Баянтал сум:

Аймгийн орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хийгдсэн гэр хорооллын гэрэлтүүлгийг асааж хэвийн үйл ажиллагаанд орууллаа. 12 дугаар сарын 14-ний өдөр сумын орон нутгийн хөгжил сангийн 6800.0 мянган төгрөгөөр биохимийн хагас автомат анализаторыг урвалжийн хамт шууд худалдан авалтаар авч эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгсөн.

2019 оны 12 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд сумын зорилтот бүлгийн 35 өрхөд 40 тн нүүрсийг олголоо.

### Сүмбэр сум:

Сумын Засаг дарга тус суманд отроор өвөлжиж байгаа Дундговь аймгийн Сайнцагаан, Сайхан-Овоо, Дэлгэрцогт сумын харьяат 9 өрхөөр орж орон нутгийн бодлого шийдвэрийг танилцуулан бэлчээр чөлөөлөх асуудлаар үүрэг чиглэл өгсөн.

Боржигин морин хуур, уртын дууны уралдааныг 4 насны ангилалаар 2 төрлөөр зохион байгуулж, 29 өвлөн суралцагчийг хамрууллаа.

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр "Сүмбэрийн мөнгөн өвөл 2019" арга хэмжээг зохион байгуулж, сумын шилдгүүдээ шалгарууллаа.

1 дүгээр багийн Засаг дарга, төмөр замын Цагдаатай хамтран төмөр замын өртөө, галт тэрэгний буудал дээр ил задгай худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэдийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, үйл ажиллагаанд хяналт тавьж, худалдаа эрхлэгч 21 иргэнд “Гэмт хэрэг

болон осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх”, “Хүнсний аюулгүй байдал”-ын тухай мэдээлэл хийж, зөвлөмж өгч ажиллалаа.

**Шивээговь сум:**

Улаан загалмайн анхан шатны хорооноос “Хүмүүнлэгийн өдөр” арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, сайн дурын шинэ гишүүдийг элсүүлэн, онцгой гишүүдийг шагнаж урамшуулсан. Уг арга хэмжээнд өсвөр улаан загалмайчид болон сайн дурын 86 гишүүн оролцсон.